

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН 2008 ОНЫ ШҮҮН
ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮНГИЙН
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2009 оны 01 дүгээр
сарын 12-ний өдөр

Улаанбаатар
ХОТ

Нэг. Эрүүгийн шүүн таслах ажиллагааны талаар

Анхан шатны шүүхүүд 2008 онд 10602 хүнд холбогдох 6878 эрүүгийн хэрэг хүлээн авч, 956 хүнд холбогдох 510 эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж, 17 хүнд холбогдох 12 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, шүүгдэгч, хохирогч эвлэрснээр 364, цагаатгах тогтоолоор 125 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, 8495 хүнд холбогдох 5812 хэргийг таслан шийдвэрлэж, оны эцэст 645 холбогдогчтой 544 хэргийн үлдэгдэлтэй байна.

Өнгөрсөн оноос шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 0,3 хувиар буурч, ял шийтгүүлэгчид 0,4 хувиар өсчээ.

Анхан шатны шүүхээр 2008 онд таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, ял шийтгүүлэгчдийг өмнөх онтой нь харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Эрүүгийн хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2007 он	2008 он	тоо	хувь	2007 он	2008 он	тоо	хувь
1	Архангай	146	98	-48	-32,88	223	146	-77	-34,53
2	Баян-Өлгий	87	96	9	10,34	135	120	-15	-11,11
3	Баянхонгор	130	155	25	19,23	177	216	39	22,03
4	Булган	119	108	-11	-9,24	177	146	-31	-17,51
5	Говь-Алтай	77	69	-8	-10,39	98	107	9	9,18
6	Говьсүмбэр	63	38	-25	-39,68	81	41	-40	-49,38
7	Дархан-Уул	304	209	-95	-31,25	465	349	-116	-24,95
8	Дорнод	188	169	-19	-10,11	272	237	-35	-12,87
9	Дорноговь	260	222	-38	-14,62	332	311	-21	-6,33
10	Дундговь	110	88	-22	-20,00	160	130	-30	-18,75
11	Завхан	113	95	-18	-15,93	149	129	-20	-13,42
12	Орхон	243	196	-47	-19,34	375	284	-91	-24,27
13	Өвөрхангай	252	160	-92	-36,51	389	251	-138	-35,48
14	Өмнөговь	125	109	-16	-12,80	204	151	-53	-25,98
15	Сүхбаатар	112	143	31	27,68	139	158	19	13,67
16	Сэлэнгэ	346	358	12	3,47	517	560	43	8,32
17	Төв	200	222	22	11,00	295	305	10	3,39
18	Увс	137	166	29	21,17	213	267	54	25,35
19	Ховд	182	180	-2	-1,10	252	253	1	0,40
20	Хөвсгөл	174	174	0	0,00	236	261	25	10,59
21	Хэнтий	200	145	-55	-27,50	281	211	-70	-24,91
22	Нийслэл	2263	2612	349	15,42	3293	3862	569	17,28
	Дүн	5831	5812	-19	-0,33	8463	8495	32	0,38

байдалтай байна.

Таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг Ховд, Булган, Дорнод, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговь, Завхан, Орхон, Дундговь, Хэнтий, Дархан-Уул, Архангай, Өвөрхангай, Говьсүмбэр аймагт 1,1 - 39,7 хувиар буурч, Сэлэнгэ, Баян-Өлгий, Төв, Нийслэл, Баянхонгор, Увс, Сүхбаатар аймагт 3,5 - 27,7 хувиар нэмэгджээ.

Ял шийтгүүлэгчид Дорноговь, Баян-Өлгий, Дорнод, Завхан, Дундговь, Булган, Орхон, Хэнтий, Дархан-Уул, Өмнөговь, Өвөрхангай, Архангай, Говьсүмбэр аймагт 6,3 - 49,4 хувиар буурч, Ховд, Төв, Сэлэнгэ, Говь-Алтай, Хөвсгөл, Сүхбаатар, Нийслэл, Увс, Баянхонгор аймагт 0,4 - 25,3 хувиар өссөн байна.

Анхаарал татаж байгаа эрүүгийн хэргийг авч үзвэл:

Д/д	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчид			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2007 он	2008 он	тоо	хувь	2007 он	2008 он	тоо	хувь
1	Хүнийг санаатай алах	250	257	7	2,80	276	285	9	+ 3,26
2	Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах	319	258	-61	-19,12	328	271	-57	-17,38
3	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	2404	1590	-814	-33,86	3725	2641	-1084	- 29,10
4	Танхайрах	552	713	161	29,17	823	1020	197	+ 23,94
5	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	129	202	73	56,59	289	432	143	+ 49,48
6	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	517	713	196	37,91	550	734	184	+ 33,45
7	Албан тушаалын гэмт хэрэг	16	25	9	56,25	34	34	0	+ 0,00
8	Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх	44	35	-9	-20,45	63	49	-14	- 22,22

байдалтай байна.

Эдгээр төрлийн гэмт хэрэг таслан шийдвэрлэсэн нийт хэргийн 65,3 хувь, ял шийтгүүлэгчдийн 64,3 хувийг эзэлж байгаа бол бусдын эд хөрөнгийг хулгайлах, танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн нийлбэр нь нийт хэрэг болон ял шийтгүүлэгчдийн 52,0 хувийг эзэлж байна.

Өнгөрсөн оныхоос бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 19,1, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 33,9, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 20,5 хувиар буурсан бол бусдыг санаатай алсан гэмт хэрэг 2,8, танхайрах гэмт хэрэг 29,2, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 56,6, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 38,0, албан тушаалын гэмт хэрэг 56,3 хувиар тус тус өсчээ.

Ял шийтгүүлэгчдийн байдлыг авч үзвэл:

Д/д	Үзүүлэлт	Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2007 он	2008 он	Тоо	Хувиар
Ял шийтгүүлэгчид. Үүнээс:	Насанд хүрээгүй этгээд	963	547	-416	- 43,20
	Эмэгтэйчүүд	710	799	89	+ 12,54
	Гадаадын харъяат	52	43	-9	-17,31
	Урьд ял шийтгүүлсэн	1904	1638	-266	-13,97
	Гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн	1496	1578	82	+ 5,48
	Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн	1742	2014	272	+ 15,61
	Ажил, сургуульгүй хүмүүс	4967	5282	315	+ 6,34

байдалтай байна.

Гэмт хэргийн улмаас нийтдээ 14 тэрбум 64 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирч, 534 хүний амь хохирч, 2565 хүний биед (хүнд, хүндэвтэр, хөнгөн) гэмтэл учирчээ.

Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн байдлыг авч үзвэл:

Д/д	Төрөл	Бүтэн жилд		Нийт ялын дотор эзлэх хувь	
		2007 он	2008 он	2007 он	2008 он
	Нийт ял шийтгүүлэгчид	8463	8495		
1	Хорих ялаар бүгд: Үүнээс	5864	6150	69.3	72.4
	а/ Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	2859	3011		
	б/ Тэнссэн	2154	2517		
	в/ Эрүүгийн хуулийн 62, 63 дугаар зүйлээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан Үүнээс:	737	555		
	а/Насанд хүрээгүй этгээд	635	447		
	б/Жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг	102	108		
	г/ Өршөөл үзүүлсэн	114	67		
2	Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн: Үүнээс	2573	2242	30.4	26.4
	а/ Торгох ял	589	419		
	б/ Албадан ажил хийлгэх ял	671	534		
	в/ Баривчлах ял	1313	1289		
3	Бусад ял	26	27	0.3	0.3
4	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ		76		0.9

байдалтай байна.

Ял шийтгүүлэгчдийн 72,4 хувьд хорих, 6,3 хувьд албадан ажил хийлгэх, 15,2 хувьд баривчлах, 0,3 хувьд бусад ял оногдуулж, насанд хүрээгүй 76 этгээдэд (0,9 хувь) хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авчээ. Мөн 4,9 хувь буюу 419 хүнийг 2 тэрбум 636 сая төгрөгөөр торгох ял оногдуулжээ.

3011 хүнд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлсэн нь хорих ял шийтгүүлэгчдийн 48.9 хувь нь болж байна.

Хорих ялыг биечлэн эдлүүлсэн ба баривчлах ялаар шийтгүүлсэн хүн 4300 байгаа нь нийт ял шийтгүүлэгчдийн 50.6 хувийг эзэлж байна.

Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ялыг 351 хүнд хэрэглэж 196,5 сая төгрөг гаргуулсны дээр, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 531 хүнд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулжээ.

Шүүх хорих ял биечлэн эдлүүлсэн 3011 хүний 71,6 хувийг жирийн, 25,9 хувийг чанга, 1,9 хувийг онцгой, 0,6 хувийг гяндангийн дэглэмд ял эдлүүлэхээр тогтоожээ.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар эрүүгийн 2235 хэрэг хүлээн авснаас 2088 хэргийг хянан шийдвэрлэж, 1127 буюу 54,0 хувьд нь тогтоолыг хэвээр үлдээж, 468 буюу 22,4 хувьд нь тогтоолд өөрчлөлт оруулж, 493 буюу 23,6 хувьд нь тогтоолыг хүчингүй болгожээ. Оны эцэст 82 хэргийн үлдэгдэлтэй гарав. 65 хэргийн хувьд эрх бүхий этгээд гаргасан гомдол, эсэргүүцлээсээ татгалзан буцаан авчээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2007 он	2008 он	2007 он	2008 он	зөрүү /+/, -/
Хянан шийдвэрлэсэн бүгд	1923	2088			
Хэвээр үлдээсэн	1054	1127	54.8	54.0	- 0.8
Өөрчлөлт оруулсан	407	468	21.2	22.4	+ 1.2
Хүчингүй болгосон	462	493	24.0	23.6	- 0.4
Үлдэгдэл	28	82			

Давж заалдах шатны шүүх 961 тогтоолыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 46,0 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар эрүүгийн 663 хэрэг хүлээн авснаас, 470 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 172 хэргийг хянаж, хариу өгсөн ба оны эцэст 21 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн эрүүгийн хэргийн шийтгэх тогтоол, магадлалын 270 буюу 54.4 хувийг хэвээр үлдээж, 106 буюу 21,4 хувийг өөрчилж, 120 буюу 24,2 хувийг хүчингүй болгожээ. Мөн Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар 26 хэргийг хянан шийдвэрлэжээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2007 он	2008 он	2007 он	2008 он	зөрүү /+/, -/
Хүлээн авсан хэрэг	751	663			
Хянан шийдвэрлэсэн бүгд	720	642			
Хянаад хүргүүлсэн	177	172			

Нийт шийдвэрлэсэн хэрэг Үүнээс:		543	496			
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн		523	470			
Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн		20	26			
Үүнээс:	Хэвээр үлдээсэн	328	270	60.4	54.4	- 6.0
	Өөрчлөлт оруулсан	88	106	16.2	21.4	+ 5.2
	Хүчингүй болгосон	127	120	23.4	24.2	+ 0.8
Үлдэгдэл		31	21			

Хяналтын шатны шүүх 226 тогтоол, магадлалыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 45.6 хувийг эзэлж байна.

Хоёр. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Анхан шатны шүүхүүд 38120 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авч, 6716 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, буцаах, харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, бүгд 28480 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 2219 хэргээр буюу 7,2 хувиар буурсан байна. Оны эцэст 2924 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Хянан шийдвэрлэсэн нийт 28480 хэргийн 8707 буюу 30,6 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 19773 буюу 69,4 хувийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцжээ.

Анхан шатны шүүхээр 2008 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг урьд онтой харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2007 он	2008 он	тоо	хувь
1	Архангай	550	626	76	+ 13,82
2	Баян-Өлгий	775	707	-68	- 8,77
3	Баянхонгор	819	833	14	+ 1,71
4	Булган	599	617	18	+ 3,01
5	Говь-Алтай	532	520	-12	- 2,26
6	Говьсүмбэр	181	311	130	+ 71,82
7	Дархан-Уул	1297	1341	44	+ 3,39
8	Дорнод	1286	1164	-122	- 9,49
9	Дорноговь	670	691	21	+ 3,13
10	Дундговь	608	560	-48	- 7,89
11	Завхан	1009	874	-135	- 13,38
12	Орхон	1238	956	-282	- 22,78
13	Өвөрхангай	1553	1635	82	+ 5,28
14	Өмнөговь	475	483	8	+ 1,68

15	Сэлэнгэ	2096	1292	-804	- 36.36
16	Сүхбаатар	442	483	+ 41	+ 9.28
17	Төв	1086	1043	- 43	- 3,96
18	Увс	737	541	-196	- 26,59
19	Ховд	962	875	-87	- 9,04
20	Хөвсгөл	1367	1383	16	+ 1,17
21	Хэнтий	674	672	-2	- 0,30
22	Нийслэл	11743	10873	-870	- 7,41
	Дүн	30699	28480	-2219	- 7,23

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг Хөвсгөл, Өмнөговь, Баянхонгор, Булган, Дорноговь, Дархан-Уул, Өвөрхангай, Сүхбаатар, Архангай, Говьсүмбэр аймагт 1,2 - 72,0 хувиар нэмэгджээ. Харин Хэнтий, Говь-Алтай, Төв, Нийслэл, Дундговь, Баян-Өлгий, Ховд, Дорнод, Завхан, Орхон, Увс, Сэлэнгэ аймагт 0,3 - 38,4 хувиар буурчээ.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь		Зөрүү /+/,/-/
	2007 он	2008 он	2007 он	2008 он	
Нийт иргэний хэрэг	30699	28480			
Иргэний эрх зүйн маргаан	11792	9480	38.4	33.3	- 5.1
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар	9316	12313	30.3	43.2	+ 12.9
Гэр бүлийн эрх зүйн маргаан	3544	3629	11.5	12.7	+ 1.2
Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	657	682	2.1	2.4	+ 0.3
Бусад эрх зүйн маргаан: Үүнээс:	5390	2376	17.7	8.4	- 9.3
Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар	48	10			
Дампуурлын тухай хуулиар	6	17			
Компаний тухай хуулиар	6	7			
Нийгмийн даатгалын багц хуулиар	1057	111			
Патентийн тухай хуулиар	2	5			
Зохиогчийн эрхийн тухай хуулиар	2	1			
Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	7	1			
Төрийн албаны тухай хуулиар	5	2			
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулиар	189	160			
Бусад хуулиар	4068	2062			

Нийт хэрэгт иргэний эрх зүйн маргаан 33,3, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн маргаан 43.2, гэр бүлийн эрх зүйн маргаан 12,7, хөдөлмөрийн эрх зүйн маргаан 2,4 хувийг тус тус эзэлж байна.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар 1633 хэрэг хүлээн авснаас 1516 хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс 600 буюу 40,0 хувьд нь шийдвэрийг хэвээр үлдээж 515 буюу 34,0 хувьд нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 401 буюу 26,0 хувьд нь шийдвэрийг хүчингүй болгож, оны эцэст 117 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2007 он	2008 он	2007 он	2008 он	зөрүү +/-,-/-
Хянан шийдвэрлэсэн бүгд	1350	1516			
Хэвээр үлдээсэн	446	600	33.0	40.0	+ 7.0
Өөрчлөлт оруулсан	406	515	30.1	34.0	+ 3.9
Хүчингүй болгосон	498	401	36.9	26.0	- 10.9
Үлдэгдэл	69	117			

Давж заалдах шатны шүүх 916 шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 60,0 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар иргэний 809 хэрэг хүлээн авч, 171-г хянан хариу өгч, 620 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн байна. Үүнээс шийдвэр, магадлалын 362 буюу 58.4 хувийг хэвээр үлдээж, 164 буюу 26,5 хувийг өөрчилж, 94 буюу 15,1 хувийг нь хүчингүй болгож, 18 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хянан шийдвэрлэсэн нийт 620 хэргээс 3 хэргийг Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар, 28 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ.

	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь			
	2007 он	2008 он	2007 он	2008 он	зөрүү +/-,-/-	
Хүлээн авсан хэрэг	931	809				
Хянаад хариу өгсөн хэрэг	228	171				
Нийт шийдвэрлэсэн хэрэг Үүнээс:	675	620				
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	642	589				
Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн	1	3				
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн	32	28				
Үүнээс:	Хэвээр үлдээсэн	285	362	42.2	58.4	+ 16.2
	Өөрчлөлт оруулсан	244	164	36.1	26.5	- 9.6
	Хүчингүй болгосон	146	94	21.7	15.1	- 6.6
Үлдэгдэл	28	18				

Хяналтын шатны шүүх 258 шийдвэр, магадлалыг өөрчилж хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 41.6 хувийг эзэлж байна.

Гурав. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Захиргааны хэргийн шүүхүүд 2008 онд 1455 нэхэмжлэл, гомдол хүлээн авч, 427 нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх буюу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангуулахаар нэхэмжлэгчид нь буцааж, 826 хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 235 хэргээр буюу 39.7 хувиар өсчээ.

Оны эцэст 202 хэргийн үлдэгдэлтэй гарсны дотор хуульд заасан үндэслэлээр 31 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, 42 хэргийн шүүх хуралдааныг хойшлуулж, 129 хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

2008 онд хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг шүүх тус бүрээр үзүүлбэл:

Д/д	Шүүх	Бүтэн жил		өсөлт, бууралт	
		2007	2008	тоо	хувь
1	Архангай	7	24	17	+ 2,4 дахин
2	Баян-Өлгий	27	47	20	+ 74,07
3	Баянхонгор	15	15	0	0,00
4	Булган	8	13	5	+ 62,50
5	Говь-Алтай	2	20	18	+ 9 дахин
6	Говьсүмбэр	6	15	9	+ 1,5 дахин
7	Дархан-Уул	11	19	8	+ 72,73
8	Дорнод	13	31	18	+ 1,38 дахин
9	Дорноговь	16	7	-9	- 56,25
10	Дундговь	3	13	10	+ 3,3 дахин
11	Завхан	5	3	-2	- 40,00
12	Орхон	32	43	11	+ 34,38
13	Өвөрхангай	21	28	7	+ 33,33
14	Өмнөговь	5	15	10	+ 2 дахин
15	Сүхбаатар	22	32	10	+ 45,45
16	Сэлэнгэ	10	16	6	+ 60,00
17	Төв	15	31	16	+ 1 дахин
18	Увс	11	30	19	+ 1.7 дахин
19	Ховд	9	15	6	+ 66,67
20	Хөвсгөл	17	28	11	+ 64,71
21	Хэнтий	11	17	6	+ 54,55
22	Нийслэл	325	364	39	+ 12,00
	Дүн	591	826	235	+ 39,76

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг маргааны төрлөөр авч үзвэл,

Маргааны төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь	
	2007 он	2008 он	2007 он	2008 он
Нийт захиргааны хэрэг	591	826		
Сонгуультай холбоотой маргаан	11	9	1.9	14.0
Төрийн албаны тухай хуулиар	68	34	11.5	12.1
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан	14	6	2.4	1.2
Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан	39	28	6.6	7.4
Газрын маргаан	129	79	21.7	19.7
Ашигт малтмалтай холбоотой маргаан	50	56	8.5	7.5

Татварын маргаан	38	25	6.4	3.9
Тендерийн маргаан	14	14	2.4	2.4
Бусад маргаан	228	575	38.6	31.8

байдалтай байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах шатаар 400 хэрэг хүлээн авч 370 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэнээс, 2 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэж, үүнээс 52.4 хувь буюу 194 шийдвэр, захирамжийг хэвээр үлдээж, 17.8 хувь буюу 66 шийдвэрт өөрчлөлт оруулж, 29.8 хувь буюу 110 шийдвэр захирамжийг хүчингүй болгож, оны эцэст 21 хэргийг үлдэгдэлтэй гарчээ. 9 хэргийг хувьд эрх бүхий этгээд гаргасан гомдлоосоо татгалзсан байна.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь			
	2007 он	2008 он	2007 он	2008 он	зөрүү /+/, -/	
Хүлээн авсан хэрэг	290	400				
Хянаад хариу өгсөн хэрэг	7	9				
Нийт шийдвэрлэсэн хэрэг Үүнээс:	263	370				
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	262	368				
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	1	2				
Үүнээс	Хэвээр үлдээсэн	147	194	55.8	52.4	- 3.4
	Өөрчлөлт оруулсан	40	66	15.2	17.8	+ 2.6
	Хүчингүй болгосон	76	110	29.0	29.8	+ 0.8
Үлдэгдэл	20	21				

Хяналтын шатны шүүх 260 хэрэг хүлээн авснаас 197 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 48 хэргийг хянан хариу өгч, одоо 15 хэргийг үлдэгдэлтэй байна. Хянан шийдвэрлэсэн 197 хэргээс 1 хэргийг Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар, 4 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ. Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн 197 хэргийн 61.4 хувь буюу 121 шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, 20.8 хувь буюу 41 шийдвэр, магадлалыг өөрчилж, 17.8 хувь буюу 35 шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2007 он	2007 он	2007 он	2008	зөрүү /+/, -/
Хүлээн авсан хэрэг	201	260			
Хянаад хариу өгсөн хэрэг	43	48			
Нийт шийдвэрлэсэн хэрэг. Үүнээс:	143	197			
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	136	192			

Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар шийдвэрлэсэн		1	1			
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан		6	4			
Үүнээс	Хэвээр үлдээсэн	84	121	58.7	61.4	+ 2.7
	Өөрчлөлт оруулсан	37	41	25.9	20.8	- 5.1
	Хүчингүй болгосон	22	35	15.4	17.8	+ 2.4
Үлдэгдэл		15	15			

Дөрвө. Бусад асуудлаар

Анхан шатны шүүхүүд бүгд 14913 (-633) хүнд захиргааны арга хэмжээ авсны дотор 1264 (+315) хүнийг 19.3 (+6.4) сая төгрөгөөр торгож, 13649 (-841) хүнд баривчлах шийтгэл ногдуулжээ.

Захиргааны зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгчийн гаргасан гомдлоор захиргааны шийтгэл ногдуулсан 263 шийтгэврийг давж заалдах журмаар хянаснаас 196 буюу 74,5 хувьд хэвээр үлдээж, 53 буюу 20,2 хувьд өөрчлөлт оруулж, 14 буюу 5,3 хувийг хүчингүй болгожээ.

Тайлангийн хугацаанд шүүхүүд ялтныг хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах тухай 2672 (+1203) материалыг хянан хэлэлцэж, 34 (-25) санал дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож, 1000 (+15) хоригдлыг эдлээгүй үлдсэн хорих ялаас нь тэнсэн суллаж, 223 (+197) хоригдлын хорих ялыг хорихоос өөр төрлийн хөнгөн ялаар сольж, 1415 (+1016) хоригдлын ял эдлэх дэглэмийг өөрчилжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 1154 (-870) сэжигтнийг баривчлах тухай материалыг хүлээн авч, 1072 (-873) сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 82 (+4) сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар 2879 (+55) хүнийг сэжигтнээр, 3042 (-603) хүнийг яллагдагчаар цагдан хорьж, 293 (+110) хүнд цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

Иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад улсын тэмдэгтийн хураамжид 1 тэрбум 915 (+683.2) сая төгрөг, үүнээс анхан шатны шүүх 1 тэрбум 530,9 (+414.8) сая төгрөг, давж заалдах шатны шүүх 323.4 (+247.4) сая төгрөг, хяналтын шатны шүүх 61.6 (20.9) сая төгрөгийг улс, орон нутгийн орлогод оруулахаар шийдвэрлэв. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр анхан шатны шүүхээс 377.1 (+103.1) сая төгрөг, давж заалдах шатны шүүхээс 80.3 сая төгрөг, хяналтын шатны шүүхээс 26.9 (+13.5) сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг зохигчдод буцаан олгохоор шийдвэрлэсэн байна.

Анхан шатны шүүхүүд нийт 67736 (-4551) хэрэг, маргааныг шийдвэрлэсний дотор эрүүгийн 6334 (-173), иргэний 35196 (-4015), захиргааны 1253 (+375) хэрэг, 14913 (-633) захиргааны зөрчил, ялтныг ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай 2672 (+1203) хүсэлт, 7368 (-716) хүнд баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох эсэх тухай асуудал хэлэлцжээ.

Ерөнхий харъяаллын анхан шатны шүүх болох сум, сум дундын нэг шүүгч дунджаар 218, дүүргийн шүүхийн нэг шүүгч дунджаар 351 хэрэг маргаан шийдвэрлэсэн байна.

Аймгийн Захиргааны хэргийн шүүхийн нэг шүүгч дунджаар 14, нийслэлийн захиргааны хэргийн нэг шүүгч дунджаар 71 хэрэг хянан шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхүүд эрүүгийн 2153, иргэний 1516, захиргааны зөрчлийн 263 бүгд 3932 хэрэг хянан шийдвэрлэжээ. Аймгийн шүүхийн нэг шүүгч дунджаар 25, нийслэлийн шүүхийн нэг шүүгч дунджаар 99 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

2008 онд - Хяналтын шатны шүүх буюу Улсын Дээд шүүх иргэний 791, эрүүгийн 642, захиргааны 245, давж заалдах журмаар 379 нийтдээ 2057 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Дээд шүүхийн нэг шүүгчид дунджаар иргэний хэрэг 158, эрүүгийн хэрэг 128, захиргааны 104 хэрэг ногдож байна.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
СУДАЛГААНЫ ТӨВ